



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ
ТҮВШНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХДЭЭ ҮР АШГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААГ ХАНГААГҮЙ,
ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН
ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

АУДИТЫН КОД:
АРА-2022/22-1-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2022 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn

Багийн ахлагч, ахлах аудитор Х.Алтанчимэг

Утас: 9006-0105 Цахим хаяг: altanchimegkh@audit.gov.mn

Аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 9921-0906 Цахим хаяг: tsogerdeneg@audit.gov.mn

Аудитор Ж.Мөнгөншагай

Утас: 90909190 Цахим хаяг: mongonshagaij@audit.gov.mn

АГУУЛГА	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН МЭДЭГДЭЛ	4-5
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	5

БҮЛЭГ 1: КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТАГТ ҮНЭЛЭХ БОЛОМЖҮЙ БАЙНА

- 1.1.Төрийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна.
- 1.2.Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнг тооцох боломжгүй байна.

БҮЛЭГ 2: “АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-НИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГГҮЙ БАЙНА.

- 2.1. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний зардлыг үр ашгийн зохистой харьцааг хянаж батлаагүй байна.
- 2.2. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн орлого бүрдүүлэлт 97.8 хувьтай байна.
- 2.3. “Архангай АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагааны зорилт түвшинг хангаагүй, үр ашиггүй байна.
- 2.4.”Архангай АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөөгүй, үр ашгийн зохистой харьцааг хангаагүй байна.

БҮЛЭГ 3: “АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

- 3.1. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.
- 3.2. “Архангай АЗЗА” ТӨХК-д тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, хяналт үр нөлөөгүй байна.
- 3.3. “Архангай АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	
УЛАМЖЛАХ САНАЛ	
ТАЙЛАН БАТАЛСАН ТУШААЛ.....	
ХАВСРАЛТ СУДАЛГАА.....	
АЛБАН ШААРДЛАГА.....	

Товчилсон үгийн тайлбар:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНЭУ	Арабын нэгдсэн эмират улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Дугаар
Дүрслэл 1	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /2019-2021 он/	16
Дүрслэл 2	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /2019-2021 он/	16
Дүрслэл 3	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байдал /2019-2021 он/	24

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	. “Архангай АЗЗА” ТӨХК-ний түүхэн товчоо	7
Хүснэгт 2	Төрийн өмчит хуулийн этгээдийн 2019-2021 оны ашигт ажиллагааны үзүүлэлт	8
Хүснэгт 3	"Архангай АЗЗА" ТӨХК-ны 2019-2021 оны байдлаарх хөрөнгийн үзүүлэлт	8
Хүснэгт 4	2019-2021 оны Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт	9
Хүснэгт 5	МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан заалтын хэрэгжилтийн байдал	11
Хүснэгт 6	ТУЗ-ийн хурлаас 2019-2021 онд гаргасан шийдвэрийг хэлэлцсэн асуудал	12
Хүснэгт 7	2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн байдал	14
Хүснэгт 8	ТУЗ-өөс дараа жилийн эдийн засгийн зорилтот түвшнийг хянасан байдал	15
Хүснэгт 9	ТӨБЗГ-аас дараа жилийн эдийн засгийн зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталгаажуулсан байдал	15
Хүснэгт 10	Гүйцэтгэх захирлын 2019-2021 оны гэрээг ТУЗ-өөс дүгнэсэн байдал	17
Хүснэгт 11	“Архангай АЗЗА” ТӨХК-ийн удирдлагын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн байдал	18
Хүснэгт 12	“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн байдал	19

Хүснэгт 13	Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн байдал	20
Хүснэгт 14	Хяналт шалгалтын мэдээлэл	22
Хүснэгт 15	“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, шийдвэрийн судалгаа	22

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

АУДИТЫН НЭР:

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

АУДИТЫН КОД:

АРА-2022/22-1/ШТА-ГА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, МҮЕА-ын баталсан нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.Үүнд:

1. Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд тавих хяналт үр нөлөөтэй эсэх.

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компаний тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, Төлөөлөн удирдах зөвлөл 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитад аймгийн ИТХ, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, “Архангай-АЗЗА” ТӨХК болон компанийн ТУЗ-ийг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 тоот тушаал “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 тоот тушаал “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд Ахлах аудитор Х.Алтанчимэг, аудитор Г.Цог-эрдэнэ, Ж.Мөнгөншагай нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 сарын 16-наас эхлэн гүйцэтгэж 2022 оны 07 сарын 01-нд Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, засаг дарга, шалгагдагч байгууллагууд болон ҮАГ-т хүргүүлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайланг “Архангай АЗЗА” ТӨХК-ийн хэмжээнд бичлээ. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2020-2021 санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэл, баримтын бүрдэлд Зам, тээврийн хөгжлийн яам болон Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны 05 сард хяналт шалгалт хийж, илэрсэн 7 заалт бүхий алдаа зөрчилд улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэнг тус байгууллагын илрүүлэлт дэх асуудлыг 3-р бүлгийн Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй эсэхэд дурьдсан болно. Мөн Архангай аймагт үйл ажиллагаа явуулдаг бусад ТӨХК-ийн тухайд ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу судалгаанд хамруулж, мэдээллийг хүргүүлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 1996 онд баталсан бөгөөд тус хуульд 29 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11, 20, 21 дүгээр зүйлд төрийн болон орон нутгийн өмчийн талаар дараах байгууллагын эрхийг хуульчилсан байна. Тухайлбал:

- **ТӨБЗГ нь:** Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах, төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах, төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох, төрийн өмчит хуулийн этгээдийн үл

хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах;

- **ТӨХЭ нь:** Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилох, төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу төрийг төлөөлөх этгээд мөн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй, Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Гишүүдийн хуралд төрийг төлөөлж оролцохоор томилогдсон төрийн өмчийн төлөөлөгч нь тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон байна, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах
- **Гүйцэтгэх удирдлага нь:** Тухайн үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох, үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах, үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах, үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох, хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх, тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах, Захирал шаардлагатай мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулан захирлын зөвлөл байгуулан ажиллуулж болох ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар батална.

Хүснэгт 1. “Архангай АЗЗА” ТӨХК-ний түүхэн товчоог хүснэгтээр харуулбал:

№	Авто зам, замын арчлалтын ТӨХК-ийн нэр	Байгуулагдсан огноо
1	“Зам анги”	1932-1964
2	“Зам барилгын анги”	1964-1981
3	“Зам барилга ашиглалтын контор”	1981-1993
4	“Авто зам” ХК	1993-2002
5	Авто зам, засвар арчлалтын” ХХК	2002-2006
6	“Архангай АЗЗА” ТӨХК	2006 оноос хойш

Тус ТӨХК нь 1932 онд анх байгуулагдсан цагаас хойш Архангай аймгийн нутгаар нэвтрэн өнгөрөх улсын чиглэлийн авто зам засвар арчлалтыг хариуцан тээврийн хэрэгсэл саадгүй зорчих нөхцлийг бүрдүүлж ирсэн 90 жилийн түүхтэй орон нутгийн авто зам, засвар арчлалтын ууган байгууллага байна.

Хүснэгт 2: Т"Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2019-2021 оны ашигт ажиллагааны үзүүлэлт
/сая.төг/

Байгууллагы нэр	Он	Орлого	Зардал	Татварын өмнөх ашиг	Татварын зардал	Ашиг/ алдагдал
Архангай АЗЗА-ТӨХК	2019	1,304.5	1,535.5	-231.0	-	(231.0)
	2020	1,370.8	1,177.6	193.2	1.7	191.5
	2021	1,285.4	1,263.9	21.5	2.1	19.4

Эх сурвалж: 2019-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан

Хүснэгтээс харахад 2019 оны санхүүгийн тайлангаар 231.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2020-2021 онд 19.4-191.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж тайлагнасан байна.

Хүснэгт 3. "Архангай АЗЗА" ТӨХК-ны 2019-2021 оны байдлаарх хөрөнгийн үзүүлэлт
/сая.төг/

Үзүүлэлт	2019.12.31-ны байдлаарх	2020.12.31-ны байдлаарх	2021.12.31-ны байдлаарх	2020/2019 он харьцуулалт хувиар	2021/2020 он харьцуулалт хувиар
Б	1	2	3	4	5
Мөнгөн хөрөнгө	82.4	331.8	273.6	302.7	(17.5)
Авлага	18.0	14.1	60.6	(21.7)	329.8
Бараа материал	106.2	92.3	160.3	(13.1)	73.7
Үндсэн хөрөнгө	989.7	948.7	916.7	(4.1)	(3.4)
Нийт хөрөнгө	1,196.3	1,386.9	1,411.2	15.9	1.8
Өр төлбөр	199.9	199.2	199.5	(0.4)	0.2
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	105.2	105.2	105.2	-	-
Хуримтлагдсан ашиг	(55.7)	(55.7)	155.2	-	(378.6)
Засгийн газрын оролцоо /эздийн өмч/	946.9	1,138.2	951.3	20.2	(16.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,196.3	1,386.9	1,411.2	15.9	1.8

Тус ТӨХК нь 2019-2021 оны жилийн эцсийн санхүү байдлын тайлангийн үзүүлэлтийг харьцуулж шинжилгээ хийхэд 2021 онд авлага 3 дахин, бараа материал 73.7 хувиар, өр төлбөр 0.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: 2019-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан/.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулдаг бөгөөд 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 4: 2019-2021 оны Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт

/сая.төг/

Байгууллагын нэр	Тайлант огноо	Үзүүлэлт	НББ, тайлагнал		Орлого бүрдүүлэлт		Хууль, тогтоомжийн хэрэгжилт		Өр төлбөр, авлагын данс		Өмч хөрөнгөтэй холбоотой		Нийт зөрчлийн дүн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Архангай АЗЗА ТӨХК	2019	Зөвлөмж			1	231.0					1	34.7	2	265.7
	2020	Зөвлөмж					1	6.6	1	-			2	6.6
	2021	Албан шаардлага					2	5.0					2	5.0
		Зөвлөмж			1	-			1	-			2	-
		Залруулсан алдаа	4	137.3									4	137.3
НИЙТ		Албан шаардлага	-	-	-	-	2	5.0	-	-	-	-	2	5.0
		Зөвлөмж	-	-	2	231.0	1	6.6	2	-	1	34.7	6	272.3
		Залруулсан алдаа	4	137.3	-	-	-	-	-	-	-	-	4	137.3
Нийт зөрчлийн дүн			4	137.3	2	231.0	3	11.6	2	-	1	34.7	12	414.6

Эх сурвалж: 2021 оны СТА-ын дүн

“Архангай АЗЗА” ТӨХК нь 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 414.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 137.3 сая төгрөгийн 4 залруулга хийгдэж, 5.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 272.3 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТАГТ ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

1.1.Төрийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна.

1.1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Уг асуудал нь орон нутгийн хэмжээнд үзэгдэхээргүй байгаа тул хамааралгүй байна.

1.1.2.Төрийн өмчит компанийн засаглалыг үнэлэх үндэсний зарчим, аргачлалтай эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Уг асуудал нь орон нутгийн хэмжээнд үзэгдэхээргүй байгаа тул хамааралгүй байна.

1.1.3.Төрийн эрх бүхий байгууллага хууль, эрх зүйн баримт бичиг хоорондын уялдааг хангаж, чиг үүргээ зохистой түвшинд хэрэгжүүлсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Уг асуудал нь орон нутгийн хэмжээнд үзэгдэхээргүй байгаа тул хамааралгүй байна.

1.2.Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнг тооцох боломжгүй байна.

1.2.1. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн засаглалыг хөгжүүлэх бодлого тогтвортой байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна.

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална”, 62 дугаар зүйлийн 62.1.1-д “компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах” гэж заасныг тус тус үндэслэн Төрийн өмчийн хорооны 2012 оны 274 дүгээр тогтоолоор “Архангай АЗЗА ТӨХК-ийн дүрэм”-ийг баталжээ.

Харин компанийн ТУЗ-өөс ТӨХК-ийн дүрмийн 7.17¹, 7.18², 7.18.1-7.18.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд ТӨХК-ийн дүрмийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг компанийн ТУЗ-ийн даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.2.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан заалт 2019 онд хэрэгжээгүй, зорилт хангагдаагүй байна.

¹ “Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна

² “Нэр дэвшүүлэх хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”

МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.2.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана” гэсэн заалтын хүрээнд тус ТӨХК-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний ашигт ажиллагааг шалгахад 2019 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн ашигт ажиллагааг хангалтгүй биелүүлж, 231.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Иймд МУЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан холбогдох заалтын хэрэгжилтийг хангах зөвлөмжийг компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлээ.

Харин “Архангай АЗЗА” ТӨХК нь 2019-2021 оны байдлаар өмч хувьчлал хийгдээгүй тул заалтын зарим хэсэг орон нутагт хамааралгүй байна.

1.2.3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хэрэгжилтийг орон нутагт тооцох боломжгүй байна.

МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулахтай холбоотойгоор 3 асуудал тусгагджээ.

Хүснэгт 5. МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан заалтын хэрэгжилтийн байдал

Тусгагдсан заалт	Заалт дэлгэрэнгүй	2021 оны тухайд биелэлт
1.1.9.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээг авна.	Уг заалтын хэрэгжилтийг тооцох боломжгүй, ТӨБЗГ болон ЗТХЯ-нд хамааруулан биелэлтийг тооцож үзэхээр байна.
4.2.4.	Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.	Архангай АЗЗА ТӨХК нь 2019 онд 92.0, 2020 онд 77.0, 2021 онд 25.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулж, 100% хэрэгжүүлж ажилласан байна.
4.4.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.	Уг заалтын хэрэгжилтийг тооцох боломжгүй, ТӨБЗГ болон ЗТХЯ-нд хамааруулан биелэлтийг тооцож үзэхээр байна.

МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1.1.9, 4.2.4, 4.4.10 дах заалтын хэрэгжилтийг орон нутгийн төрийн өмчит компанийн хувьд биелэлт тооцох боломжгүй, ТӨБЗГ болон ЗТХЯ-нд хамааруулан биелэлтийг тооцохоор байна.

1.2.4.Компанийн ТУЗ хууль, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн хэдий ч дэд хороодын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн өмчийн хорооны 2012 оны 274 дүгээр тогтоолоор баталсан “Архангай АЗЗА” ТӨХК-ийн дүрэм”-д “Архангай АЗЗА” ТӨХК нь 100 хувь төрийн өмчит ба авто зам засвар арчлалт, хайрган болон хатуу хучилттай авто зам, гүүр барих үндсэн чиг үүрэгтэй гэжээ.

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг 2017-2022 оны байдлаар Төрийн өмчийн хорооны тогтоолоор 18 гишүүнийг шинээр томилж үүнээс 9 гишүүнийг чөлөөлсөн байна.

Компаний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн ТУЗ нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна", Төрийн өмчийн хорооны 2012 оны 274 дүгээр тогтоолоор баталсан "Архангай АЗЗА ТӨХК-ний дүрэм"-ийн 7.2-т "ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна", 7.12-т “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан этгээд байна” гэсэн тус тус заалтын хүрээнд “Архангай АЗЗА” ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус 3 гишүүнийг томилжээ.

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн ТУЗ нь 2019 онд 4 удаа хуралдаж 11 тогтоол, 1 тэмдэглэл, 2020 онд 3 удаа хуралдаж 7 тогтоол, 1 тэмдэглэл, 2021 онд 3 удаа хуралдаж 5 тогтоол, 1 тэмдэглэл гаргасан байна.

Хүснэгт 6. ТУЗ-ийн хурлаас 2019-2021 онд гаргасан шийдвэрийг хэлэлцсэн асуудлаар ангилж харуулбал:

№	Хэлэлцсэн ерөнхий асуудал	Шийдвэрийн тоо				Эзлэх хувь
		2019	2020	2021	Нийт	
1	Тухайн жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийн тухай	1	1	1	3	11.5
2	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон гэрээ, түүний биелэлтийн тухай	4	2	2	8	30.8
3	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон хөрөнгө актлах тухай	2	1	2	5	19.2
4	Бүрэлдэхүүн өөрчлөх, шинээр томилох, чөлөөх тухай	4	-	-	4	15.4
5	Буцалтгүй тусламж олгох тухай	1	3	1	5	19.2
6	Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай		1	-	1	3.8
НИЙТ		12	8	6	26	100.0

Хүснэгтээс харахад нийт 26 шийдвэрийн 30.8 хувь нь төрийн өмчит хувьцаат компаний тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл захиралтай байгуулах гэрээ түүний биелэлтийг, 19.2 хувь нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт, эд хөрөнгө актлах асуудлыг, 11.5 хувь нь тухайн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг баталгаажуулах, 15.4 хувь нь ТУЗ-АРА-2022/22-1/ШТА-ГА

ийн бүрэлдэхүүн өөрчлөх, шинээр томилох, чөлөөлөх асуудлыг тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн нь тус компанийн ТУЗ нь дүрмийн хүрээнд үндсэн зорилт үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж үзэхээр байна.

Харин ТУЗ-ийн дэргэдэх “Аудитын хороо”, “Нэр дэвшүүлэх хороо”, “Цалин урамшууллын хороо”-ноос 2019-2021 оны байдлаар хэрэгжүүлсэн ажлын тайлан, дүгнэлттэй холбоотой баримт материалыг аудитад хамруулаагүй тул компанийн дүрмийн 7.17, 7.18, 7.19 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй дэд хороодын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй гэж үзлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. “АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-НИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГГҮЙ БАЙНА.

2.1. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний зардлыг үр ашгийн зохистой харьцааг хянаж батлаагүй байна.

2.1.1. “Архангай АЗЗА” ТӨХК нь 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний зардлыг төлөвлөхдөө үр ашгийн зохистой харьцааг хангаагүй байна.

Тус ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1³, 20.3⁴, компанийн дүрмийн 8.9.3⁵ дахь заалтын хүрээнд 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг өмнөх 3 жилийн ажлын үзүүлэлт, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг үндэслэн компанийн ТУЗ-д хүргүүлжээ.

Хүснэгт 7. 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн байдал

№	Үзүүлэлт	2019 он			2020 он			2021 он		
		хүргү үлсэн санал	хянас ан	Батла гдсан	хүргү үлсэн санал	хянас ан	Батла гдсан	хүргү үлсэн санал	хянас ан	Батла гдсан
1	Нийт борлуулалтын орлого	1,099.6	1,099.6	1,099.6	1,118.2	1,118.2	1,118.2	1,314.8	1,314.8	1,314.8
1.1	үндсэн орлого	1,081.4	1,081.4	1,081.4	1,077.3	1,077.3	1,077.3	1,224.0	1,224.0	1,224.0
1.2	бусад орлого	18.2	18.2	18.2	40.9	40.9	40.9	90.9	90.9	90.9
2	Нийт зардал	1,077.6	1,077.6	1,077.6	1,095.8	1,095.8	1,095.8	1,288.5	1,288.5	1,288.5
2.1	Удирдлагын зардал	159.0	159.0	159.0	199.4	199.4	199.4	194.6	194.6	194.6
2.2	Цалин, урамшуулалын зардал	274.4	274.4	274.4	304.5	304.5	304.5	399.4	399.4	399.4
2.3	Хөрөнгө оруулалтын зардал	92.0	92.0	92.0	77.0	77.0	77.0	25.1	25.1	25.1
2.4	Нийгмийн хариуцлагын зардал	-	-	-	-	-	-	-	-	-
2.5	Бусад зардал	-	-	-	-	-	-	-	-	-
3	Татварын өмнөх ашиг	21.9	21.9	21.9	22.4	22.4	22.4	26.3	26.3	26.3
4	Цэвэр ашиг/алдагдал/	19.8	19.8	19.8	20.1	20.1	20.1	23.7	23.7	23.7
5	Ногдол ашиг	1.9	1.9	1.9	2.0	2.0	2.0	2.3	2.3	2.3
6	Татвар, хураамж, шимтгэл	182.6	182.6	182.6	198.3	198.3	198.3	222.0	222.0	222.0
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.98	0.98	0.98	0.98	0.98	0.98	0.98	0.98	0.98
8	Нийт ажиллагаадын тоо	46	46	46	36	36	36	39	39	39
9	Нийт хөрөнгийн дүн	1,275.9	1,275.9	1,275.9	1,196.2	1,196.2	1,196.2	1,386.9	1,386.9	1,386.9

³ “Захирал дараахь эрх, үүрэгтэй”

⁴ “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”

⁵ “Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, батлуулах”

Хүснэгтээс харахад 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлого, зардлыг төлөвлөхдөө борлуулалтын 1 төгрөгт ногдох зардлыг 98 мөнгөөр тооцож төлөвлөсөн нь үр ашгийн зохистой харьцааг хангаагүй байна.

2.1.2. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн ТУЗ нь эдийн засгийн зорилтот түвшин нь үр ашгийн зохистой харьцаа хангасан эсэхийг үндэслэлтэй тооцож хянаагүй байна.

ТӨХК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1⁶, компанийн дүрмийн 7.3.2⁷ дахь заалтын хүрээнд гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж, шийдвэрлэн ТӨБЗГ-т хүргүүлсэн байна.

Хүснэгт 8. ТУЗ-өөс дараа жилийн эдийн засгийн зорилтот түвшнийг хянасан байдал

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоолын дугаар
1	"Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай	2018.11.22	15
2	"Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай	2019.11.21	3/9
3	"Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай	2020.11.20	11

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн хэрэгцээ шаардлага, төсвийн төлөвлөлтийн тооцоолол, үндэслэлийг шалгахгүйгээр ТУЗ-өөс тогтоол гарган баталж, ТӨБЗГ-т хүргүүлсэн байна.

2.1.3.ТӨБЗГ-аас “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны эдийн засгийн зорилтот түвшнийг баталсан байна.

ТӨБЗГ нь тус ТӨХК-ийн дүрмийн 6.4⁸, 6.4.6⁹ дахь заалтын хүрээнд ТӨБЗГ-аас 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Хүснэгт 9. ТӨБЗГ-аас дараа жилийн эдийн засгийн зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталгаажуулсан байдал

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоолын дугаар
1	"Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай	2018.12.25	665

⁶ “Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох”

⁷ “Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтот түвшинг үндэслэн компанийн бизнес төлөвлөгөөг батлах”

⁸ “Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ”

⁹ “компанийн зорилтот түвшинг батлах”

2	"Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай	2019.12.17	586
3	"Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай	2020.12.08	618

2.2. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн орлого бүрдүүлэлт 97.8 хувьтай байна.

2.2.1. Тус ТӨХК нь төлөвлөсөн орлогын 2.2 хувийг дутуу төвлөрүүлжээ.

Дүрслэл 1.

Тус компани нь 2019 онд 1,099.6 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг батлуулсан ба гүйцэтгэлээр 1,304.5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 18.6 хувиар, 2020 онд 1,118.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг батлуулсан ба гүйцэтгэлээр 1,370.7 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 22.6 хувиар тус тус давуулсан байна.




Харин 2021 онд 1,314.8 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг батлуулсан ба гүйцэтгэлээр 2.2 хувь буюу 29.4 сая төгрөгийн орлогыг дутуу бүрдүүлсэн нь орон нутгийн авто зам, засварын ажлын орлого 2.3 сая төгрөгөөр, машин мехназим түрээслүүлэх орлого 27.1 сая төгрөгөөр тус тус тасарсантай холбоотой байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "Захирал дараахь эрх, үүрэгтэй", 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", контрактын гэрээний 3.3-т "... тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг контрактын хавсралтад тусгасан үзүүлэлтүүдээр биелүүлэн ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүргийг хүлээнэ ..." гэсэн заалтыг хэрэгжүүлж, төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн хийж байх албан шаардлагыг гүйцэтгэх удирдлагад хүргүүлээ.

2.2.2. “Архангай АЗЗА” ТӨХК нь улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

Дүрслэл 2.



"Архангай АЗЗА" ТӨХК нь улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварыг 2019-2021 оны байдлаар төлөвлөгөөнөөс 7.0-18.4 хувь буюу 15.4-33.6 сая төгрөгөөр давуулж татварын орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

2.3. “Архангай АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагааны зорилт түвшинг хангаагүй, үр ашиггүй байна.

2.3.1. ТӨХК-ний 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн тооцоо шинжилгээг хийгээгүй байна.

Компаний гүйцэтгэх удирдлагаас 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын өгөөж, бараа материалын эргэц, өрийн болон ашигт ажиллагааны шинжилгээгүй байгаа нь компанийн дүрмийн 8.9.2¹⁰ дах заалтын чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Санхүү тайлангийн үзүүлэлтэд үндэслэн үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийж, үр нөлөөг дүгнэж удирдлагын шийдвэр гаргах түвшинд бодит мэдээллээр хангах, үр ашигтай ажиллах арга хэмжээ авах зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад хүргүүлээ.

2.3.2. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг ТУЗ-өөр дүгнүүлээгүй байна.

ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлагаас 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын өгөөж, бараа материалын эргэц, өрийн болон ашигт ажиллагааны шинжилгээг хийгээгүй, ТУЗ-д танилцуулж дүгнүүлээгүй байна.

Харин ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2019-2021 оны контрактын гэрээний биелэлтийг ТУЗ-өөр хэлэлцэж, дүгнэж ажиллажээ.

Хүснэгт 10. Гүйцэтгэх захирлын гэрээг ТУЗ-өөс дүгнэсэн байдал

ТӨХК-ний нэр	Үзүүлэлт	2019		2020		2021	
		Авбал зохих оноо	Авсан оноо	Авбал зохих оноо	Авсан оноо	Авбал зохих оноо	Авсан оноо
"Архангай АЗЗА" ТӨХК	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл	55	35	55	53.8	55	54
	Тайлангийн үр дүн, хууль тогтоомжийн биелэлт	20	19	20	20	20	19
	Харъяалах салбарын яам, төрийн захиргааны байгууллагын үнэлгээ /шийдвэрийн хэрэгжилт/	25	22	25	21.8	25	24.2
	Нийт оноо	100	76	100	95.6	100	97.2

Гүйцэтгэх захирал нь 2019 онд орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн, алдагдалтай ажилласан, ТӨБЗГ болон ТУЗ-ийн шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн байдлыг харгалзан гэрээний биелэлтийг 76%-иар үнэлжээ.

Харин 2020-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангаж орлогыг бүрэн төвлөрүүлсэн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон хууль тогтоомжийг хангалттай биелүүлсэн гэж үнэлэн гэрээг 95.6-97.2 хувь буюу "Сайн" гэж үнэлсэн байна.

¹⁰ “компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах”

2.3.3. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлагаас байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээг үр ашиггүй хэрэгжүүлжээ.

ТӨХК-ийн дүрмийн 11.1-д “...Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх санхүүгийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй хоорондоо шууд холбоотой хэлцлийг хэлнэ ...”, 11.2-д “... Сонирхоллын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлнэ ...” гэж заасны дагуу гүйцэтгэх удирдлагаас 2019 онд "Саруул харгуй" ХХК-тай туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулж Өндөр-Улаан сумын төвд 1км хатуу хучилттай авто замын ажлыг 563.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

Ажлын хүрээнд “Архангай АЗЗА” ТӨХК нь 2019 онд 512.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн ба гүйцэтгэлээр 653.3 сая төгрөгийн зардал гарч 141.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Иймд Ажил гүйцэтгэх их хэмжээний хэлцэл болон гэрээг байгуулахдаа ТЭЗҮ, зураг төсвийн дагуу зардлыг үндэслэлтэй тооцож, үр ашигтай хэрэгжүүлж байх албан шаардлагыг “Архангай АЗЗА” ТӨХК-ний гүйцэтгэх захиралд хүргүүлжээ.

2.4.”Архангай АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөөгүй, үр ашгийн зохистой харьцааг хангаагүй байна.

2.4.1. ТӨХК-ийн удирдлагын зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

Компанийн 2019-2021 оны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зардлын төлөвлөлтийг компанийн ТУЗ болон ТӨБЗГ-аар хянуулж батлуулсан байна.

Хүснэгт 11. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн удирдлагын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн байдал

№	Зардлын зүйл	2019			2020			2021		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар
1	ТУЗ болон дэд хороодын гишүүдийн цалин	17,880.0	16,540.0	(7.5)	27,480.0	27,480.0	-	27,480.0	25,766.5	(6.2)
2	НДШ	2,324.4	2,249.4	(3.2)	4,149.5	3,773.4	(9.1)	3,819.2	3,756.3	(1.6)
3	Албан томилолт	609.0	606.5	(0.4)	609.9	600.8	(1.5)	6,000.0	-	(100.0)
4	Бичиг хэрэг	35.0	20.0	(42.9)	20.0	17.5	(12.5)	29.0	21.8	(24.8)
5	Аудитын хөлс	500.0	500.0	-	1,000.0	469.0	(53.1)	1,000.0	281.1	(71.9)
6	Бусад зардал /хурлын/	450.0	450.0	-	450.0	174.8	(61.2)	780.2	-	(100.0)
7	Гүйцэтгэх захирал	21,600.0	21,600.0	-	26,400.0	26,400.0	-	26,400.0	26,400.0	-

/Сая.төг/

8	Ерөнхий инженер	16,632.0	16,632.0	-	16,200.0	16,200.0	-	17,400.0	16,200.0	(6.9)
9	Ерөнхий нягтлан бодогч	21,072.0	21,072.0	-	18,360.0	18,360.0	-	18,360.0	18,360.0	-
НИЙТ		81,102.4	79,669.9	(1.8)	94,669.4	93,475.5	(1.3)	101,268.4	90,785.7	(10.4)

Дээрх хүснэгтээс “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны удирдлагын зардлыг төлөвлөснөөс 1.3-10.4 хувиар буюу 1.2-10.5 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан байна. Компанийн ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг 2020 онд 1 удаа шинэчилжээ.

2021 онд албан томилолт болон бусад хурлын зардалд гүйцэтгэл гаргаагүй, удирдлагын зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулжээ.

2.4.2. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөөгүй, үр ашгийн зохистой харьцааг хангаагүй, арвилан хэмнэлтгүй зарцуулжээ.

Компаний 2019-2021 оны үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлд харьцуулалт хийж үзэхэд үйл ажиллагааны зардлыг 2019 онд 42.5 хувиар, 2020 онд 7.5 хувиар зардлыг хэтрүүлэн зарцуулжээ. Хүснэгтээр харуулбал:

	2019		Хувь	2020		Хувь	2021		Хувь
	Төлөвлө гөө	Гүйцэтгэ л		Төлөвлө гөө	Гүйцэтгэ л		Төлөвлө гөө	Гүйцэтгэ л	
	1,077.6	1,535.5	42.5	1,095.8	1,177.6	7.5	1,288.5	1,263.9	(1.9)

Хүснэгт 12. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн байдал

№		2019		Хувь	2020		Хувь	2021		Хувь
		Төлөвлө гөө	Гүйцэтгэ л		Төлөвлө гөө	Гүйцэтгэ л		Төлөвлө гөө	Гүйцэтгэ л	
1	Улсын чанартай з/засварын ажил	1,099.7	1,304.4	18.6	1,118.2	1,370.6	22.6	1,314.8	1,285.4	(2.2)
2	Орон нутагт гэрээ тендерээр хийх ажил	854.2	662.5	(22.4)	850.0	1,190.7	40.1	1,137.5	1,139.7	0.2
3	Бусад орлого /гирээсийн/	227.3	561.4	147.0	227.3	42.0	(81.5)	86.4	88.6	2.5
4	Бусад орлого /гирээсийн/	18.2	80.5	342.3	40.9	137.9	237.2	90.9	57.1	(37.2)
5		1,077.6	1,535.5	42.5	1,095.8	1,177.6	7.5	1,288.5	1,263.9	(1.9)
6	Шалгаруулах олон улсын хурлын зардал	159.0	159.3	0.2	199.4	167.4	(16.0)	194.5	194.4	(0.1)
7	Салбарын зардал	21.9	(231.0)	-	22.4	193.1	762.1	26.3	21.5	(18.3)
8	Салбарын зардал	19.8	(231.0)	-	20.1	191.5	852.7	23.6	19.4	(17.8)
9	Төсвийн төлбөрт нийт дүн	182.6	216.2	18.4	195.9	211.6	8.0	222.0	237.4	6.9
10	Салбарын зардал	1.9	-	(100.0)	2.0	19.1	855.0	2.4	12.1	404.2
11		46	39	(15)	39	36	(8)	39	36	(8)
12		274.6	251.4	(8.4)	300.5	292.9	(3)	399.4	325.5	(18.5)

13	з 0000000000 1 0000000000 000000	0.98	1.18	20.4	0.98	0.86	(12.2)	0.98	0.98	-
	Хөрөнгө оруулалт	92.0	92.0	-	77.0	58.3	(24.3)	25.0	25.0	-

Дээрх хүснэгтийн 11 дэх мөрнөөс харахад батлагдсан орон тоо 2019 онд 46, 2020-2021 онд 39, гүйцэтгэлээр 2019 онд 39, 2020-2021 онд 36 орон тоотой батлагдсан орон тооноос дутуу ажиллажээ.

Нийт цалингийн санг 2019-2021 онд 3-18.5 хувиар хэмнэж ажилласан байна.

“Архангай АЗЗА” ТӨХК нь 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний зардлыг төлөвлөхдөө борлуулалтын 1 төгрөгт ногдох зардлыг 98 мөнгөөр тооцож ТӨБЗГ-аар батлуулсан ба гүйцэтгэлээр борлуулалтын 1 төгрөгт 98-1 төгрөг 18 мөнгөний зардал гаргасан нь үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөөгүй, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

Тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулж байх зөвлөмжийг “Архангай АЗЗА” ТӨХК-ний гүйцэтгэх захиралд хүргүүлээ.

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангаар 2009 онд анх бүртгэгдсэн 13 жилийн насжилттай АНЭУ-ын Кувейтийн сангийн хөнгөлттэй зээлээр олгосон машин, механизм, тоног төхөөрөмжтэй холбоотой 198.6 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй байна.

Өр төлбөрийн асуудалтай холбоотойгоор 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар гүйцэтгэх удирдлагад зөвлөмж хүргүүлсэн хэдий ч “Архангай АЗЗА” ТӨХК-ийн хэмжээнд шийдвэрлээгүй уг асуудал нь МУЗГ, ЗТХЯ-ны хэмжээнд шийдвэрлэх асуудал тул уламжилж шийдвэрлүүлж өгөх талаар тайлбар хүсэлтийг ирүүлээд байна. Эх сурвалж: “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2022.06.29-ны өдрийн 85 дугаар албан бичиг

Иймд төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 13 жилийн насжилттай урт хугацаат өр төлбөрийг барагдуулах, холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх талаар аудитын тайлангаар дамжуулан ҮАГ-т уламжиллаа.

2.4.3. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг компанийн ТУЗ болон ТӨБЗГ-аар батлуулсан байна.

ТӨХК нь 2019-2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан эрх байгууллагаар хянуулан батлуулжээ.

Хүснэгт 13. ТӨХК-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн байдал

/сая.төг/

ТӨХК-ний нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
"Архангай АЗЗА" ТӨХК	92.0	92.0	77.0	58.3	25.0	25.0
Нийт дүн	92.0	92.0	77.0	58.3	25.0	25.0

ТӨХК нь 2019 онд грашийн барилга 32.0 сая, бутлуур /2 фракцын конвертэй/ 50.0 сая, асфальт заводын их засвар 10.0 сая, нийт 92.0 сая төгрөгийн, 2020 онд чиргүүлтэй шланз машин 45.0 сая, приус суудлын автомашин 13.5 сая, асфальт заводыг тээвэрлэх, угсрах, суурилуулах, их засварын ажилд 18.5 сая, нийт 77.0 сая төгрөгөөр, 2021 онд асфальт заводын цахилгаан хангамжийн ажилд 25.0 сая төгрөг зарцуулж сүүлийн 3 жилд нийт 195.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгцээ шаардлагыг тооцож батлуулжээ. Төлөвлөхгүйгээр хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгээгүй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: “АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

3.1. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.

3.1.1. ТӨХК-ийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагын хяналт хангалттай байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д заасныг удирдлага болгон ЗТХЯ болон Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас “Архангай АЗЗА” ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Хүснэгт 14. Хяналт шалгалтын мэдээлэл

/сая.төг/

Харъяа яам	Газар, хэлтэс	Шалгалтын зорилго	Хамарсан огноо	Зөрчлийн дүн	Үүнээс	
					Залруулсан	Албан шаардлага
ЗТХЯ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэл	2020-2021	129.9	50.5	79.4

Хяналт шалгалтаар 13 заалт бүхий 129.9 сая төгрөгийн зөрчлөөс 5 заалт бүхий 50.5 сая төгрөгийн зөрчлийг шалгалтын явцад арилгуулж, 7 заалт бүхий 79.4 сая төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн ба биелэлтийг “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2022.06.17-ны өдрийн 80 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан байна.

3.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 онд санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Хүснэгт 15. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, шийдвэрийн судалгаа

/сая.төг/

Тайлант огноо	Аудит хийсэн байгууллагын нэр	Аудитын төлбөр	Аудитын дүгнэлт	Нийт зөрчлийн		Үүнээс					
						Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2019	Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	2.0	Хязгаарлалттай	2	265.7	-	-	2	265.7		
2020	Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК	2.1	Зөрчилгүй	2	6.6			2	6.6		

2021	Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК	2.1	Зөрчилгүй	8	142.3	2	5.0	2		4	137.3
Нийт дүн		6.2	-	12	414.6	2	5.0	6	272.3	4	137.3

Эх сурвалж: “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтүүд

Дээрх хүснэгтээс харахад 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12 заалт бүхий 414.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4 заалт бүхий 137.3 сая төгрөгийн алдааг залруулж, 2 заалт бүхий 5.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6 заалт бүхий 272.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллажээ.

“Архангай АЗЗА” ТӨХК нь 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг тухайн жилдээ компанийн ТУЗ-өөр хэлэлцүүлж, баталгаажуулжээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлж, зөрчлийг давтан гаргаагүй нь хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.

3.2. “Архангай АЗЗА” ТӨХК-д тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, хяналт үр нөлөөгүй байна.

3.2.1. ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны хяналт үр нөлөөгүй байна.

Архангай АЗЗА ТӨХК-ийн ТУЗ нь компанийн дүрмийн 7.14¹¹ дэх заалтын хүрээнд Аудитын хороог анх 2017 онд 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба байгуулагдсан цагаас хойш компанийн дүрмийн 7.17.1-ээс 7.17.6 дахь заалтын дагуу хяналт тавьж, дүгнэлт гаргах, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Компанийн дүрэмд заасан чиг үүргээс гадна “Архангай АЗЗА” ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл, орлогын бүрдүүлэлт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг ТУЗ-д хүргүүлээ.

3.2.2. Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, хяналт үр нөлөөгүй байна.

“Архангай АЗЗА” ТӨХК нь дүрмийн 10.5¹², 10.6¹³, 10.7¹⁴ гэсэн заалтын хүрээнд дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, дотоод хяналтын нэгдсэн бодлогыг тодорхойлоогүй байгаа нь төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл, өр төлбөр, санхүүгийн хүндрэл, техник технологийн

¹¹ “... Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороотой байна ...”

¹² “Компаний өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ”

¹³ “дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрхзүйн мэдлэг туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна”

¹⁴ “Дотоод хяналтын алба нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй”

шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын болон бусад эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй болгосон байна.

Цаашид төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагаа хууль, УИХ, ЗГ болон компанийн Хувьцаа эзэмшигчд, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрт нийцэж байгаа эсэхэд дотоод хяналтын албаар хяналтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг гүйцэтгэх удирдлагад хүргүүллээ.

3.3. “Архангай АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байна.

3.3.1. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн болон орон нутгийн төрийн байгууллагуудын мэдээлэл солилцдоггүй үйл ажиллагаа нь уялдаагүй байна.

ТӨХК-ийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтад ТӨБЗГ-аас хяналт тавьж, шийдвэрлэн ажилладаг тул аймгийн ОНӨГ-аас хамааралгүй байна. Эх сурвалж: аймгийн ОНӨГ-ын 2022.06.24-ны өдрийн 375 тоот албан бичиг


Мөн ТӨХК нь өдөр тутмын зарлагын гүйлгээгээ аймаг дахь Хаан болон Төрийн банкны харилцах дансаар хийдэг тул гүйлгээнд тавих хяналтгүй байна.

3.3.2. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна.

ТӨХК нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтын хүрээнд компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас 2019-2021 оны үндсэн зорилго, зорилтын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, санхүү, төсвийн гүйцэтгэлийн талаар олон нийтэд ил тод мэдээлжээ. Тухайлбал:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Дүрслэл 3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байдал /2019-2021 он/



Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2019 онд 61 мэдээллийг байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроосон, 2020 онд 93 мэдээллийг бүрэн байршуулсан, 2021 онд 173 мэдээллийг байршуулахаас 10

мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 3 жилийн дундажаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 96.6 хувьтай байна.

Мөн ТӨХК нь албан ёсны цахим хуудасгүй ба 2019-2021 онуудад авто зам, зам арчилгаатай холбоотой цаг үеийн мэдээллийг иргэд олон нийтийн цахим мэдээллийн санд 1.1 мянган дагагчтай ARKHANGAI AZZA-TUHK пэйж хуудсаар, 21.9 мянган дагагчтай орон нутгийн SODMEDIA пэйж хуудсаар мөн 20.6 мянган дагагчтай "AB" телевизээр 63 мэдээллийг байршуулж ажилласан байна.



“Архангай АЗЗА” ТӨХК-ийн ТУЗ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.14¹⁵ дэх заалтын хүрээнд 2021 онд Тариат суман дахь үл хөдлөх хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр ТӨБЗГ-т хүргүүлжээ.

--oOo---

¹⁵ “Төлөөлөн удирдах зөвлөл энэ хуульд заасан тайлан, бусад мэдээллийг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй”

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.
Үүнд:

- ✓ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТАГТ ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.
- ✓ “АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-НИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГГҮЙ БАЙНА.
- ✓ “АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ИЙН ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

Аудитын ерөнхий дүгнэлт:

“АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХДЭЭ ҮР АШГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААГ ХАНГААГҮЙ, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

Аудитын явцад нийт **369.3 сая төгрөгийн** зөрчил илэрсэнээс төлөвлөсөн орлогыг дутуу бүрдүүлсэнтэй холбоотой 29.4 сая төгрөгийн, гэрээ хэлцлийг үр ашиггүй хэрэгжүүлж, алдагдалтай тайлагнасан 141.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслах зогсоох 2 албан шаардлага, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг оновчтой төлөвлөх, үр ашгийн зохистой харьцааг хангах, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн 5 заалт бүхий зөвлөмж, урт хугацаат өр төлбөрийг барагдуулах холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх 198.6 сая төгрөгийн саналыг гаргаж ҮАГ-т уламжлан хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

-----o0o-----

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга Н.Сугаржавд

1. Компанийн дүрэмд заасан чиг үүргээс гадна “Архангай АЗЗА” ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл, орлогын бүрдүүлэлт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд аудитын хорооноос тавих хяналтыг хэрэгжүүлэх

ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ю.Ганзоригт

1. МУЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний судалгаа, бодит тоо мэдээлэлд үндэслэн төлөвлөж, үр ашгийн зохистой харьцааг, тооцож, түүнийг хангах арга хэмжээг авч, биелэлтийг үнэлж байх
3. ТӨХК-ийн тухайн жилийн санхүү тайлангийн үзүүлэлтэд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийж, үр нөлөөг дүгнэж, компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад танилцуулан шийдвэр гаргах түвшинд бодит мэдээллээр хангах, үр ашигтай ажиллах арга хэмжээ авах
4. Тухайн жилийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн зардлын төлөвлөгөөг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад анхаарч ажиллах

УЛАМЖЛАХ САНАЛ:

Аудитын явцад ажиглагдсан зүйл, аудитын дүнд үндэслэн дараах асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

Үүнд:

1. “Архангай АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайланд тусгагдсан 13 жилийн насжилттай 198.6 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг барагдуулах талаар холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх